

## Обон ба Фүнэко Нагаши

2018/08/29

Батболд Тогтохтөр

Жил бүр Китаками голын эрэг дээр төрөл бүрийн хэлбэр, өнгө бүхий завийг шатаан, голоор урсгадаг нэгэн баяр болж өрнөдөг. Энэхүү баярыг 'Фүнэко Нагаши (舟つこ流し)' буюу 'завь голоор урсгах баяр' гэж нэрлэдэг бөгөөд Японы жил бүрийн 8 сард 3 өдрийн турш үргэлжилдэг Обоны баярын сүүлчийн өдөр тохиолддог юм. Энэ жил надад энэхүү баярыг үзэх завшаан гарсан юм.



< Фүнэко Нагаши >

Мориокад 8 сард Санса Одоригоас эхлүүлэн Ханаби галын наадам зэрэг баярууд болдог ба ихэнхдээ баяр ёслолын уур амьсгалтай санагдана. Харин Обоны баярыг бусадтай харьцуулбал илүү тайван, намуунаар тэмдэглэнэ. Энэхүү баяр нь өвөг дээдэс, нас барагсдыг дурсан хүндэтгэх Буддын шашны баяр ба орой гудамжаар хүмүүс гэр бүлээрээ лаа, дэнлүү чимээгүйхэн гэрийнхээ гадна асаан тавьж байгаагаас нь баярын ариун дагшин байдал нь мэдрэгдэх болно.

Баярын сүүлчийн өдөрт Фүнэко Нагашиг тэмдэглэдэг ба завь шатаахаас гадна, шөнө голоор дэнлүү урсгадаг ба галын наадмаар өндөрлөдөг юм.



< Китаками голын эрэг >

Лууны толгойгоор чимсэн 15 ширхэг завийг уламжлалт Фүндоши өмсгөл өмссөн 12 орчим эрчүүд татан шатааж голоор урсгана. Завь дээрээс ёслолын буудлага буудуулах ба лууны ам, нүднээс гарах гал, мөн ёслолыг үзэн хоол идэж буй үзэгдчид дээр үнс унаж ирэх нь баярыг илүү сүртэй, сонирхолтой болгож харагдуулж байсан.



<Галын наадам>

Хэдийгээр өмнөх Ханаби наадамтай харьцуулахад, хэмжээгээр жижиг байсан ч, маш сонирхолтой, гайхалтай баяр болж өндөрлөсөн. Ямар ч шашны хүн бай, японы уламжлалд сонирхолтой хүн бүхэнд би энэхүү баярыг үзэхийг санал болгоно. Би хувьдаа японоос удахгүй нутаг буцах гэж байгаа олон улсын оюутнуудтай хамт явсан ба тэдэнд японы сүүлчийн энэхүү дурсамж нь тааламжтайгаар үлдсэн гэж бодож байна.